



Хэвлэлийн мэдээлэл
ШУУД ТАРААХ
2011 оны 9 дүгээр сарын 21

Олон Улсын Валютын Сан
Вашингтон, Колумбын тойрог.
20431 АНУ

**Монгол Улсад Стэнд-бай хөтөлбөрийн дараах хяналтыг хийсэнтэй холбогдуулан
ОУВС-ийн ажлын хэсгээс гаргасан мэдэгдэл**

Олон Улсын Валютын Сангийн (ОУВС) ажлын хэсэг 2011 оны 9 дүгээр сарын 14-20 өдрүүдэд Монгол Улсад ажиллаж, Стэнд-бай хөтөлбөрийн дараах хяналтын яриа хэлэлцүүлгийг хийлээ. ОУВС-ийн Ази, Номхон далайн бүсийн төвийн дэд захирал Стивэн Барнэтгаар ахлуулсан ажлын хэсэг Монгол Улсын төр засгийн болон бусад байгууллагуудтай уулзаж, сүүлийн үед макро эдийн засагт гарсан өөрчлөлт, бодлогын асуудлаар ярилцлаа.

Ажлын хэсгийн айлчлалыг дүгнэж ноён Барнэтт дараах мэдэгдэл гаргав. Үүнд:

“Монгол Улсын эдийн засаг саяхан нүүрлэсэн хямралаас гайхалтай хурдан сэргэж чадлаа. Эрх баригчид макро эдийн засгийн зөв оновчтой бодлого хэрэгжүүлэх тууштай байр суурь баримталж, зэсийн дэлхийн зах зээлийн үнийн сэргэлт, олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэг цагаа олсон зэрэг нь энэхүү амжилтыг тодорхойллоо. Нүүрсний үйлдвэрлэл хурдацтай өсч, уул уурхайн томоохон хоёр төсөл эдийн засгийн эргэлтэнд удахгүй орох гэж байгаа нь Монгол Улсын эдийн засгийг гэрэлт ирээдүй хүлээж, нийт ард иргэд хөгжил цэцэглэлтийг хүртэх боломж бүрдээд байгааг харуулж байна.

“Ийм нөхцөл байдалд ОУВС Монгол Улс дахь суурин төлөөлөгчөө энэ сарын сүүлчээр дуусгавар болгон татах шийдвэр гаргаад байна. Сүүлийн хоёр жилийн хугацаанд сэтгэл зүрхээ зориулан ажилласан ноён Рамлоганд талархлаа илэрхийлье. Суурин төлөөлөгчийг татах шийдвэр нь Монгол Улсын эдийн засаг хямралаас богино хугацаанд сэргэж, нэг хүнд ногдох орлого хурдацтай өсч байгаа болон манай байгууллагын төсвийн нөхцөл байдалтай шууд холбоотой юм. Бид Монгол Улс, ОУВС-ийн хоорондын харилцааг ихэд үнэлж явдаг бөгөөд нягт хамтын ажиллагаагаа хадгалахын төлөө зорин ажиллаж байна. Иймд дотоодын ажилтнуудаа үргэлжлүүлэн ажиллуулж, Токио дахь бүсийн төвөөс удирдах болно. Тус бүсийн төвийн захирал ноён Шого Ишийгийн өнгөрсөн долоо хоногт хийсэн айлчлал нь бидний хамтын ажиллагааг бэхжүүлэхийн төлөө байгааг улам бататгаж өгсөн.

“Манай ажлын хэсэг эрх баригчидтай эдийн засгийн төлөв байдал, бодлогын сорилт бэрхшээлийн талаар илэн далангүй яриа хэлэлцүүлэг хийлээ. Эрдэс баялгийн арвин их нөөц баялгаа эдийн засгийн эргэлтэнд оруулсанаар Монгол Улсын эдийн засгийг гэрэлт ирээдүй хүлээж байна гэдэгт бид итгэлтэй байна. Гэхдээ бидний зүгээс ойрын хугацаанд эдийн засгийн төлөвийг доройтуулж болзошгүй томоохон эрсдэлүүд байна гэж үзэж байна. Нэгдүгээрт, эдийн засагт хэт халалт явагдаж байна. Инфляцийн түвшин аль хэдийн өндөр түвшинд очсон байна. Мөн цаашид нэмэгдэх төлөвтэй. Энэ нь ядуу, эмзэг бүлгийнхэнд хүнд дарамт болж, Монгол Улсын хувийн хэвшлийн үйл ажиллагаагаа үр ашигтай явуулах чадварыг доройтуулж байна. Эдгээр дарамт шахалтын эсрэг сөрөхийн оронд макро эдийн засгийн бодлогууд 2009 оны хямралын үеэр ноёрхож байсан тэлэлт- агшилтын чиг шугам уруу буцаж ороод байна. Хоёрдугаарт, макро эдийн засгийн тогтвортой бус байдлын дотоод эрсдэл ийнхүү нэмэгдсэн нь дэлхийн эдийн засгийн төлөв доройтсонтой давхцаж байна. Хэрвээ бараа түүхий эдийн үнэ дэлхийн зах зээл дээр огцом унавал Монгол Улсын экспортын болоод улсын төсвийн орлого аль аль нь хүнд цохилтонд орно. Одоогийн өндөр инфляцийг цаашид өсөн нэмэгдэхээс сэргийлж, эмзэг байдлыг бууруулахын тулд ямар бодлого авч хэрэгжүүлэх шаардлагатай нь тодорхой байна. Улсын төсвийн зарлагыг хязгаарлаж, мөнгөний бодлогыг хатууруулах шаардлагатай байна.

“2011 оны улсын нэгдсэн төсвийн зарлага 30 гаруй хувиар огцом нэмэгдэж батлагдсан. Эдийн засагт халалт үүсээд байгаагийн үндсэн шалтгаан нь энэ юм. Гэтэл Засгийн газраас төсвийн зарлагыг энэ оны дөрөвдүгээр улиралд багтааж ДНБ-ий 6,5 хувьтай тэнцэх хэмжээгээр нэмэх санал боловсруулаад байгаа нь маш их эрсдэлтэй, бодлогогүй алхам болно. ДНБ-ий өсөлт хоёрдугаар улиралд 17 хувиас давж, хэрэглээний барааны импорт 80 гаруй хувиар өссөн. Байдал ийм байхад төсвийн зарлагыг нэмэх нь халж байгаа эдийн засгийг огт шаардлагагүй үед нь улам бүр эрчимжүүлэх алхам болно.

“2012 оны төсвийн төслийн хувьд мөн зарлагыг УИХ-аас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан хэмжээнд багтаах буюу багасгах нь зүйтэй. Төсвийн зарлагын тэрхүү хязгаарлалтын хүрээнд Засгийн газар нийгмийн халамжийн зорилтот тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай.

“Эцэст нь, байгуулагдаад удаагүй байгаа Хөгжлийн банк бидний санааг ихээхэн зовоож байна. Хөгжлийн банкныг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг тойрч гарах арга хэрэгсэл эсвэл засгийн газрын төсвөөс гадуурх зарлагыг санхүүжүүлэх нэг механизм болгон ашиглах ёсгүй. Эс тэгвээс төсвийн эрсдэлийг нэмэгдүүлж, төсвийн ил тод байдлыг доройтуулж, өнгөрсөн онд батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн ач холбогдлыг бууруулах болно.

“Мөнгөний бодлого дээр саяхан хатууруулах арга хэмжээ авсныг сайшааж байгаа боловч хангалтгүй гэж үзэж байна. Төв банкнаас энэ зорилгоор олон янзын арга

хэрэгслийг ашиглах нь зүйтэй. Бодлогын хүүгийн түвшинг дахин өсгөх хэрэгтэй байна. Он гарснаас хойш бодлогын хүүгийн түвшин суурь инфляцийн өсөлтийн хурдацаас хоцорч, банкны зээл өндөр хурдацаар өсөх боломжийг бүрдүүлсэн (бодит утгаараа 50 орчим хувийн өсөлттэй байна). Гэвч дан ганц хүүг өсгөх нь хангалтгүй байх болно. Иймд, макро-зохистой байдлын арга хэмжээнүүдийг нэмж авч, зээлийн өсөлтийн хурдацыг сааруулах шаардлагатай байна. Үүнд өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг нэмэгдүүлэх, шинээр олгож буй зээл дээр алдагдлын сан байгуулахыг шаардаж эхлэх, банкны заавал байлгах нөөцийн хувь хэмжээг өсгөх, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтүүдийг чангатгах зэрэг болно. Банкны системд зээлийн чанартай холбоотой асуудал бэрхшээл (ямар хор хохирол авчирч болдогийг 2009 он тодорхой харуулсан) ирээдүйд үүсэхээс сэргийлж, бизнесийн мөчлөгийн энэ цаг хугацаанд эрсдэлийг урьтан удирдаж, зохистой байдлын үзүүлэлтүүдийг мөрдүүлэх нь онцгой чухал байна.